
Доктор (Ph.D), МУИС-ийн дэд профессор М.ОТГОНБАЯР
Доктор (Ph.D) Б.ДАГЗМАА
МУИС-ийн Философийн тэнхмийн багш

2.8. БИОЛОГИ ЯЛГААНЫ НИЙГЭМ, УЛС ТӨРИЙН ҮР ДАГАВАРЫН ТАЛААРХИ ФЕМИНИСТ ФИЛОСОФИЙН ЗАРИМ ҮНДЭСЛЭЛ

Түлхүүр үг: феминизм, бэлгийн мэдрэмж, шоовдор байдал, патриарх нийгэм, засаглал, улс төрийн эрх чөлөө

1960-аад оноос негрүүдийн иргэний эрхийн төлөөх чөлөөлөх хөдөлгөөн, дайныг эсэргүүцсэн иргэдийн хөдөлгөөн, феминистүүдийн хөдөлгөөн гэсэн гурван чиглэлээр нийгмийн хөдөлгөөнүүд АНУ, Баруун Европт эрчээ авсан билээ. Эдгээрээс феминист хөдөлгөөнд нь бусад хөдөлгөөний адил амжилт, алдаа аль аль нь байдаг боловч нийгмийн оюун санааны амьдралд бусад хөдөлгөөнөөсөө илүүтэйгээр өөрчлөлт оруулж иржээ. Үүний үр дүнд өнөөдөр эмэгтэйчүүдийн асуудлыг тусгайлан судалдаг академик судалгаа болох “эмэгтэйчүүд судлал” /women`s studies/, нийгэмтүүхийн тодорхой нөхцөл байдал дахь хүйсүүдийн харилцааны асуудлыг судалдаг “жендерийн судалгаа” /gender studies/ зэрэг байгууллагууд үүсэн, эл асуудлыг эрхэлдэг факультет, тэнхим, төвүүд дэлхийн их сургуулиудад олноор байгуулагдан ажиллаж байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний онол, үзэл санааны үндэс нь феминизмийн философи юм. XX зууны 70-аад он хүртэлх үеийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөний гол зорилго бол улс төрийн, нийгмийн, соёлын институтууд дэх эмэгтэйчүүдийн шоовдор байдлын шалтгааныг илрүүлж, “жам ёсны” субординацийг эрс шүүмжлэх, “ондоон” байдлын нийгмийн үндсийг илрүүлэх явдал байлаа. Феминистүүд янз бүрийн шалтгаанаар, тухайлбал: хүйс, арьсны өнгө, ангийн хамаарал, шашин, нас, хөгжлийн бэрхшээл, бэлгийн хандлага зэргээсээ болж шоовдорлогдсон хүмүүсийн нийгмийн эрс ялгарлыг арилгах; хүч үл хэрэглэх; хамтрах зэрэг зорилтыг улс төрийн зөвлөмж болгож эхэлсэн аж.

Жендерийн харилцаа нь нарийн төвөгтэйгээр бүтэцжиж, нийгмийн амьдралын тэгш бус тогтолцоонд агуулагдсан байдаг. Феминизмийн онолчид нийгмийн болон институциональ бүхий л харилцааны уг чанар дахь жендерээр нөхцөлдсөн уг шинжийг илрүүлэхийг чармайж ирсэн юм.

Өнөөг хүртэлх хүн төрөлхтний нийгэм, бүх түүхэн иргэншлүүд бүгд патриарх /эрэгтэйчүүд давамгайлсан/ шинжтэй байгаа билээ. Үйлдвэрлэл, сургууль, шинжлэх ухаан, улс төрийн институтууд, санхүү гэх мэт нийгэм дэх тодорхой эрх мэдлийн бүх талбар нь түүхийн бүх үед эрэгтэйчүүдийн гарт бүрэн оршиж ирсэн бөгөөд эдүгээ ч оршсоор байна. Патриархи нийгмийн институтууд нь улс төр, нийгэм, эдийн засгийн бүх хэлбэрт төдийгүй, бүх шашинд ч гүнзгий үндэс суурьтай байдаг.

Түүхэнд тийнхүү эрэгтэй хүн л жинхэнэ утгаараа нийгмийн үйл ажиллагааны бараг бүх төрлийн гол субъект болж, харин эмэгтэй хүний үүрэг бол зөвхөн гэр бүл, бусдын нүдэнд ил харагддаггүй хувийн амьдралын хүрээ мөн хэмээн эмэгтэйчүүдийг нийгмийн улс төрийн амьдралаас шахан гаргаж иржээ. Эртний грек-ромын үеэс авахуулаад ихэнх онолчид: эмэгтэйчүүдийн биологи онцлог болон түүнтэй холбоо бүхий соёлын загвар бол тэднийг эрх мэдлийн бүтцээс гадуур болгож, тухайлбал улс төрийн болон иргэний эрхийн идэвхийг нь хязгаартай болгоход хүргэдэг гэж үзжээ. Иймээс ч улс төрийн онол, нийгмийн сэтгэлгээний түүхэнд “эмэгтэйчүүдийн асуудал” бараг байхгүй, байж байлаа гэхэд тэр нь дан андроцентрист шинжтэй юм.

Сонгодог үе дэх улс төрийн сургаальд нийтийн ба хувийн хүрээг эрс заагладаг. Тухайлбал эртний грекчүүд ойкос (oikos), полис (polis) гэсэн хоёр хүрээг хатуу зааглаж, ойкос бол гэрийн, нөхөн үржихүйн хүрээ, харин полис бол нийгмийн хүрээ мөн гээд иргэний эрх, эрх чөлөөг гагцхүү полис-т хамааруулан үздэг байв. Ийнхүү эмэгтэйчүүд улс төрийн амьдралыг тодорхойлогч эрх чөлөөний талбарын гадна үлджээ.

Либерализмын эрин үе гэж алдаршсан шинэ үе хүрч иртэл эмэгтэйчүүдийн эгалитари эрхийг төдийлөн анхаарсангүй. Эмэгтэй хүнийг ердөө л эмэгтэйнх нь үүднээс тоодоггүй байв. Ийнхүү улс төр, нийгмийн хүрээ эмэгтэйчүүдгүй оршин тогтнохын зэрэгцээ олон нөхцөлд эмэгтэй хүний бүр эсрэг шинжтэй болсон ажээ. “Эмэгтэйчүүдэд үнэхээр боломж бүхий үйл ажиллагааны салбар байсангүй. Тийм ч учраас олон мундаг эмэгтэй өнөөдөр шинэ байдлыг шаардаж байгаа юм; тэгээд гэхдээ... тэдний шаардлага бол өөрсдийн хүйсийг өргөмжлөх явдал биш... харин тэд хууль эрхтэй хөг нийлэх, эрх чөлөө нь зөвхөн элэг доог болсон тийм нөхцөл байдалгүй байх тийм бололцоог тодорхой болгохыг л хүсч байгаа юм”¹ гэж францын экзистенциалист философич, феминист онолыг үндэслэгч Симона де Бовуар тэмдэглэжээ.

¹ Миллет К. Теория сексуальной политики. / Пер. с англ. Вопросы философии. 1999. №9

Хүйс бол хүний нийгмийн статусыг тогтоон илэрхийлдэг ба улс төрийн далд утгатай байдаг². Бид “улс төрийн” гэдгийн дор нэг бүлэг хүмүүс бусад бүлэг хүмүүстээ хяналт тавьдаг хүч, засаглалын механизмыг ойлгож байна. Өнөөг оролцуулаад бүх түүхэн дэх хүйсүүдийн нийгмийн ялгавартай байдлын жинхэнэ уг чанарыг “улс төр” гэдэг үг гайхалтай тодруулж чадах юм. Ийм ч учраас өнөөдөр уламжлалт албан ёсны улс төрийн бодлогын концептуаль (онолын баримтлалын) тогтолцооноос илүүтэйгээр эрх мэдлийн тухай философи, психологийг боловсруулах, улс төрийн онолд засаглалын харилцааг уламжлалт нэг л загвараар биш байдлаар гаргах зайлшгүй шаардлагатай байна.

Улс төрийн мөн чанар нь эрх мэдэлд оршдог. Тэр эрх мэдэл нь эсвэл зөвшилцлөөр эсвэл хүчээр хэрэгждэг. Хүйсийн талаархи улс төрийн бодлогын түүхэнд зөвшилцөл нь темперамент, үүрэг, статусын патриарх үндсэн загварт эм хүйс заавал захирагдан нийгэмших замаар биелдэг ажээ. Үүнд, статусын тухайд ч гэсэн эрэгтэйчүүд дээд, төвийн, харин эмэгтэйчүүд доод, захын байр суурьтай байж иржээ. Темпераментын тухайд бие хүний шинжүүд нь хүйсийн стереотиптэй тохирч төлөвшдөг учраас хүчирхэг, ухаалаг, идэвхит гэх мэт шинж нь эрэгтэйчүүдийнх, харин сул дорой, мунхаг, дагалдагч зэрэг нь эмэгтэйчүүдийнх болдог гэнэ. Хүйсийн үүргийн хувьд хүүхэд асрах зэрэг гэрийн ажил нь эмэгтэйчүүдэд, харин бусад бүх бололцоонууд, сонирхол зэрэг нь эрэгтэйчүүдэд оногдоно. Статусаараа дээгүүр нь гол үүрэг гүйцэтгэнэ. Учир нь түүнд давамгай байх темперамент илүү хөгжсөн байдгаа улс төрийн давуу эрхтэй болдог.

Ийнхүү сэтгэлийн уг сурвалжит нийгмийн шинжүүд нь хүйсийн биологи ялгаан дээр суурилдаг гэж патриархат шашин, үзэл суртал номлодог.

Феминист философичид патриархи нийгэмд төлөвшиж буй темпераментын ялгаа нь хүний биологи уг чанартай холбоогүй бөгөөд тиймээс үүрэг болон статусын ялгаа ч гэсэн хүйсийн биологи ялгаатай хэмээн үндэслэж бичдэг болсон. Ийм ч учраас францын экзистенциалист философич, феминизмыг үндэслэгч Симона де Бавуар: “Эмэгтэй хүн төрдөггүй, харин эмэгтэй хүн болдог” гэсэн дүгнэлтийг эмэгтэй хүний (охин, бүсгүй, ээж гэсэн) насны өсөлтийн явцад нь түүний бие махбодод болон бие хүний нь хувьд гардаг өөрчлөлтүүдийг судалсны үндсэн дээр хийжээ.

Эрэгтэйчүүд илүү булчинлаг, хүчтэй байдаг нь бүх сүүн тэжээлтний бэлгийн дагавар шинж буюу биологийн үндэстэй бөгөөд энэ нь хоол, хүнс, физик дасгалаар

² Симона де Бовуар. Второй пол. /пер с французского. Смб 1997. С. 149

соёлд бэхжижээ. Гэхдээ энэ шинжийг категори болгон иргэншлийн хүрээнд улс төрийн утгаар хэрэглэж болохгүй нь эдүгээ үед ойлгомжтой болсон юм. Угтаа патриархи нийгэм дэх эрэгтэйчүүдийн давуу байдал бол физик хүч чадал дээр үндэслэсэн биологи биш, харин аливаа улс төрийн уриа лозунгийн адилаар үнэлэмжийн систем дээр үндэслэдэг байна. Улс төрийн харилцаанд арьсны өнгөний болон ангийн ялгаа хүчтэй байдаг бол патриархи нийгэм дэх эрэгтэйчүүдийн давуу байдалд физик хүч, биологийн шинж чухал биш юм.

Нийгмийн зарим бүлгийн статус нь ихээхэн тогтвортой, тэдний давуу байдал нь бат бэх байдгийн учир бол хүлээн зөвшөөрөгдсөн улс төрийн бүтцэд бусад бүлгийнхэн нь ямар ч төлөөлөлгүй байдгаас болж иржээ. Дарлагдсан бүлгүүд нь оршин буй улс төрийн институтэд тэгш бус төлөөлөлтэй байдаг, үүнийхээ улмаас тийм бүлгүүд иргэншсэн улс төрийн тэмцэлд оппозици болоход нь саад болдог. Тухайлбал монголын хүн амын 49 хувь эрэгтэй, 51 хувь эмэгтэй хүйсийн харьцаанд өнгөрсөн социализмын үед тухайн үеийн МАХН-ын бүрэлдхүүнд 70:30, Намын Төв Хороонд 97:3, Улс төрийн товчоонд 100:0 байсан. 2001 оны байдлаар Монгол улс парламентад суугаа эмэгтэйчүүдийнхээ эзлэх 10,5 хувиар дэлхийн улс орнуудаас 62-р байрыг Азербайджантай хуваан эзэлж байлаа. Тэгвэл 2004 оны УИХ-ын сонгуулиар 3,8 хувьд хүртэл буурч лалын орнуудын түвшинд хүрсэн үзүүлэлттэй болжээ. Дэлхийн хэмжээнд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл Скандинавын орнуудад 37,9 хувь, Америкд 15,5 хувь, Азид 13,4 хувь, Европт /Скандинавын орнууд орохгүй/ 12,5 хувь, Номхон далайн орнуудад 8,3 хувь, Арабын орнуудад 3,3 хувь байна³.

Хүйсүүдийн хоорондын харилцааны энэ систем бол илүү боловсронгуй “дотоод колоничлол”-ын нэг загвар юм. Симона де Бовуарын бичснээр эмэгтэйчүүд захирагдмал нөхцөлд орших болсны шалтгаан нь: “нэгд, эмэгтэйчүүдийг янз бүрийн түвшинд объект болгон хувиргах эрчүүдийн стратеги; хоёрт, эмэгтэйчүүд өөрсдөө сайн дураараа эрчүүдэд байр сууриа тавьж өгсөн явдал, ингэснээрээ эмэгтэйчүүд экзистенциаль хариуцлагаасаа амархан мултрах бололцоотой болсон байдал мөн”⁴ гэжээ.

Иргэдийн тэгш эрхийн асуудал нь ихээхэн чухал зүйл авч өнөө хэр эмэгтэйчүүдийн ялгаварлалын асуудал ээдрээтэй хэвээр байна. Тухайлбал өндөр хөгжилтэй зарим улсад ч гэсэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөлс төлөлт ялгаатай байх нь

³ Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоо: Тулгарч буй бэрхшээл, цаашдын хандлага. УБ.: 2004, х.7

⁴ Симона де Бовуар. Второй пол. /пер с французского. Смб 1997. С. 723-740

хууль бус гэлээ ч, эмэгтэйчүүд бага цалин авдаг хэвээр байна. Тэгш төлөх тухай хууль гарахаас өмнө 1970 онд Англид эмэгтэй хүн эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн хөлсний 63%-тай тэнцэх хөлс авч байв. 1993 он гэхэд байдал өөрчлөгдсөн ч 79%-д л хүрэх болжээ. АНУ-ын Хөдөлмөрийн Яамнаас гаргасан статистикаар цагаан арьст эрэгтэйн дундаж орлого 6704 доллар, өнгөт арьстан эрэгтэйнх 4277 доллар байгаа бол цагаан арьст эмэгтэйнх 3991 доллар, өнгөт арьс эмэгтэйнх 2816 доллар⁵ байна. Патриархи нийгмийн үндсэн институт бол гэр бүл байдаг. Бодгаль хүн, нийгмийн бүтэц хоёрын дунд байдгаараа гэр бүл нь улс төрийн болон бусад эрх мэдэл хүрч чаддаггүй тэр газарт хяналт, дарангуйллаа тогтоож чаддаг онцлогтой. Патриархи нийгмийн суурь хэсэг, үндсэн хэрэгсэл болох хувьдаа гэр бүл ба гэр бүл дэх үүргийн хуваарилалт нь уг нийгмийнхээ эх дүр (прототип) байдаг. Патриархи нийгэмд эрэгтэйчүүд өрхийн тэргүүн байж, өмчлөх, өв залгамжлах зэрэг эрх нь дан тэдэнд л байдаг.

Хүн төрөлхтний хөгжлийн үндсэн гурван үе шатанд ерөнхийдөө бүрэн тохирсон гэрлэлтийн гурван гол хэлбэр байсан. Тэдгээр нь зэрлэг үед бүлгээрээ гэр бүл бололцох ёс, бүдүүлэг үед хосолмол гэр бүл, соёлжсон үед эр эмийн үнэнч байдлыг зөрчих явдал ба янханчлал нэмээс болсон дан гэр бүлийн (моногами) тохирч байлаа гэж Энгельс дүгнэжээ. Тэдгээрийн дотроос пуналуа буюу хосолмол өрх гэрийн үеүүдэд эмэгтэйчүүд нь нэр хүнд, эрх мэдэлтэй байж эдгээр үеүүдэд уг гарлыг эхээр нь тогтоодог байсан ба нийтээрээ газар тариалан эрхэлж, нийтийн нөөцөөс хэрэглэцгээж, ер нь бүх зүйл нийтийн байсан бөгөөд хувийн өмч гэж байдаггүй байсан байна. Эд баялаг өсөхийн хирээр нэг талаас гэр бүлийн дотор эрийг эхнэрээс нь илүү ихээр нөлөөтэй болгож, нөгөө талаар өв залгамжлах уламжлалыг хүүхдийн эрх ашигт нийцүүлэн өөрчлөх хүсэл эрмэлзлэл бий болжээ. Ийм үндсэн шалтгаан нөхцөлтэйгээр энэ үеэс эхлэн уг гарлыг эрэгтэйчүүдээр тогтоох болж эхийн шугамаар өв залгамжлах эрх өөрчлөгдөн оронд нь эцгийн шугамаар өв залгамжлах болжээ. Ингэж эхийн эрхт ёсыг халсан нь эмэгтэйчүүдийн даян дэлхийн түүхэн ялагдал⁶ байв хэмээн Энгельс дүгнэжээ.

Үүнээс хойш өрх гэрийн моногам ёсонд шилжсэн байна. Гэхдээ энэхүү моногам ёс нь зөвхөн эмэгтэйчүүдэд хамаардагаас биш, эрэгтэйчүүдэд хамаардаггүй ёс болж тогтжээ. Тухайлбал гэрлэлтийг ганцхан эр нь цуцалж эхнэрээ хаяж болно, эрэгтэй нь

⁵ Миллет К. Теория сексуальной политики. / Пер. с англ. Вопросы философии. 1999. №9

⁶ Маркс К., Энгельс Ф. Түүвэр зохиол. 3-р боть. УБ.: 1997, х.278 дахь талд энэ тухай үзнэ үү

завхайрч, өөрийн боол эмэгтэйчүүдээс татвар эм чөлөөтэй авч болдог бол эмэгтэй нь гэр бүлийн ариун байдлыг хадгалах үүрэгтэй байжээ.

Нэг эхнэртэй /эртэй/ байх ёс нь эрэгтэй эмэгтэй хоёрын хооронд харилцан тогтсон холбооны байдлаар, ялангуяа тэр холбооны дээд хэлбэрийн байдлаар түүхэнд үүсч гарсан юм огт биш ажээ. Энэ ёс нь эрэгтэй эмэгтэй хоёрын нэг нь нөгөөгөө боолчлох байдлаар үүсчээ. Ийнхүү М.Веберийн тодорхойлсончлон хүйсүүдийн хоорондын харилцаа нь захирах ба захирагдах гэсэн хэлбэртэй байсныг бүхий л түүх гэрчилж байна.

Нэг хүний гарт, тэгэхдээ эрэгтэй хүний гарт их баялаг бөөгнөрөөд, тэр баялгийг өөр хүний биш, харин чухамхүү тэр хүний хүүхдүүдэд өв залгамжлуулах ёс тогтсоны улмаас моногам ёс үүсчээ..

Гэр бүлийн дотор эрэгтэйчүүд ноёрхох явдал бол түүний эдийн засгийн ноёрхолын ердийн үр дагавар мөн бөгөөд тэр нь энэ ноёрхолын хамт арилна. Энэ талаар Симона де Бовуар: яагаад ингэсний учрыг бид одоо болтол мэддэггүй, үүний нэгэн адилаар яагаад хувийн өмч эмэгтэйчүүдийг дарангуйлах дарангуйллыг төрүүлснийг Энгельс тайлбарлаагүй гэж шүүмжилжээ.

"Улс төрийн талбар", "улс төр" гэдэг ойлголтуудын хэвшмэл агуулгыг эвдэх нь /деконструкци/ орчин үеийн феминист хөдөлгөөний гол зорилго болж байгаа билээ. Учир нь патриархат нийгэм дэх өөр хоорондоо тодорхой ялгаа заагтай "нийтийн" ба түүний дагавар болсон "хувийн" гэх хүрээнүүд бол нилээд тохиолдолд эрэгтэй болон эмэгтэй хүний амьдралын үндсэн талбарууд байж иржээ.

Гэхдээ феминизм нь өөр өөр хэлбэрээр илэрдэг. Тухайлбал радикал феминизмыг сурталчлагчид "улс төр" гэдэг ойлголтыг их өргөн утгаар хэрэглэх болжээ. Орчин үеийн нийгмийн болон соёлын амьдралын бүх хүрээнд болж буй үйлийг тэд "улс төр" гэдэг ойлголтоор тэмдэглэх болов. Радикал феминистууд бол: "хувийн амьдрал бол улс төрийн амьдралын нэг хэсэг мөн" гэдэг лозунг дэвшүүлдэг. Урьд өмнө зөвхөн эмэгтэй хүнийх гэсэн тодотголтой байсан асуудлууд, тухайлбал үр хөндөлт, эмэгтэй хүнийг хүчирхийлэх, sexual harassment, хүүхдийн хүмүүжил гэх мэт асуудал орчин цагийн ардчилсан улс төрийн хэллэгт идэвхтэй хэлэлцэгдэх боллоо.

1980-аад оны үед улс төрийг тодорхойлох феминист үзлийн төвд "хүчээ мэдэрэхүй-empowerment" гэдэг баримтлал чухал байр суурь эзлэх болсон. Орчин үеийн феминистүүдийн үзлээр эрэгтэйчүүд эрх мэдлийг ойлгодог бол нөлөөлөх,

дарангуйлах боломж гэж ойлгодог бол эмэгтэйчүүд үүний эсрэг эрх мэдэл бол ямар нэгэн юм хийх чадвар, бололцоо гэдэг үүднээс ойлгодог юм.

Орчин үеийн феминистүүдын хэлэлцэж байгаа өөр нэг нийгэм-улс төрийн чухал асуудал бол өнгөт буюу хар арьстан, шар арьстан гэх эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөний асуудал юм. Тэдний нийгмийн болон улс төрийн үйл ажиллагаанд хамрагдах талбар, хүрээг цагаан арьстай эмэгтэйчүүдийнхтэй харьцуулбал бага, идэвх оролцоо нь муу байгааг феминист хөдөлгөөнийхөн хүлээн зөвшөөрч, үүнийг тэдний анхаарвал зохих шинэ асуудал мөн гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм.

Феминист философи дахь нэг гол категори бол "бэлгийн мэдрэмж" билээ. Бодгаль хүний зайлшгүй шинж бол түүний гетеросексуал чанар мөн гэдэг тодорхойлолт XX зууны 80-90-ээд онуудаас хойш нийгэм улс төрийн хүрээнд ихээхэн маргаан дэгдээж байгаа нэгэн онцлог асуудал юм. Хүний бэлгийн мэдрэмжийг нийгэм ямар нэгэн шахалт дарамт учруулснаар тодорхойлох боломжгүйг Кэйт Миллет, Кэрол Пэйтман зэрэг феминистууд онцлон тэмдэглээд, гетеросексуал чанараас гадна бэлгийн мэдрэмжийн бусад хэлбэрүүдийг нийгэм хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийдэг учир гетеросексуал чанар хүний зайлшгүй хэмээн нэрлэгддэг тийм шинж болж хувирдаг гэж үзсэн юм. Ийнхүү нийгмийн гомофоби ба төрийн зүгээс явуулж буй хэлмэгдүүлэлтийн бодлогыг феминистууд эсэргүүцэн "сексуальное меньшинство"-гийн эрхийг хамгаалах төслүүдийг боловсруулж, феминист хөдөлгөөнтэй анхнаасаа өөрсдийгөө адилтгаж байгаагүй нийгмийн тийм өөр бүлгүүдтэй хамтран ажиллаж эхэлсэн юм. Үүний үр дүнд урьд нь нуугдмал далд хэлбэртэй байсан хомосексуалистууд, лесбичүүдийн асуудал орчин үед улс төрийн бодлогын түвшинд яригдах болж, хувийн амьдрал улс төрийн амьдралтай салшгүй холбоотой байдаг гэсэн феминистуудын тезисыг батлах үндэслэгээ болж өгчээ.

Феминист онол ардчилсан үйл явцын хөгжилд ач холбогдол өгдөгийн улмаар иргэншлийн тухай ардчилсан баримтлал, феминизм хоёрын харилцаа хамаарлын асуудал XX зууны 1980-1990-ээд онуудаас хойш академик түвшиний маргааны гол асуудал болж хувирсан. Тухайлбал, америкийн феминист Кэрол Пэйтман "Бэлгийн гэрээ" гэдэг зохиолдоо "Иргэн гэж хэн юм бэ? Тэр иргэний үйл ажиллагааны талбар нь эрчүүдийн загвараар, эрчүүд ноёрхсон байдлаар бүтээгдсэн болохоор тэнд иргэн хүн юу хийдэг вэ? Либераль ардчилсан нийгэмд эмэгтэйчүүд хэдийгээр иргэд мөн боловч тэд энэхүү иргэншлийг патриархи эрх мэдлийн хүрээнд л тэмцэж олж авсан

билээ. Тэнд эмэгтэй хүний шинжүүдийг аанай л тоож үздэггүй шүү дээ”⁸ гэж бичсэн байдаг. Пейтманы үзлээр “нийгмийн гэрээний” онол нь түүхийн зөвхөн нэг хэсгийг л харуулдаг бөгөөд гэтэл орчин үеийн патриархи буюу эрчүүд эмэгтэйчүүдийг улс төрийн хувьд ноёрхсон нийгмийн үндсэнд “бэлгийн гэрээ” оршдог. Үүнийг урьд өмнө огт авч үзэж байсангүй. Эрчүүд ба эмэгтэйчүүдийн өвөрмөц хэрэгцээг адил тэгш үнэлсэн, хүйсийн ялгааг тооцсон иргэншлийн загвар олох ёстой.

Америкийн феминист философичид улс төрийн ертөнцтэй эмэгтэй хүний харилцах харилцааг нухацтай судлан үзэхийн тулд бие биедээ сөрөг шинжтэй гэмээр хоёр баримтлалыг санал болгосон юм. Тэдгээр нь “шоовдор байдлын баримтлал”, “нэгдмэл байдлын баримтлал” хоёр юм. Вирджиния Сапиро хэмээх философич өөрийн бичсэн “Эмэгтэйчүүдийн улс төрийн интеграци” гэдэг зохиолдоо өгүүлснээр улс төрийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн интеграци бол нэг талаас улс төрийн амьдралд эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, нөгөө талаас улс төрийн зүгээс эмэгтэйчүүдийн хувь заяанд үзүүлэх нөлөө гэсэн хоёр элементээс бүрддэг. Эмэгтэй хүн улс төрийн тодорхой эрх мэдэлгүйгээр нийгмийн нөхөн үржихүй, бэлгийн мэдрэмж, гэр бүл дэх эд хөрөнгийн болон хөдөлмөрийн хуваарь, гэр бүлийн салалт зэрэг засгийн газрын түвшинд зохицуулалтаа олдог боловч эмэгтэй хүний хувийн амьдралын эрх мэдлийн хувь заяаг шууд тодорхойлдог олон асуудлыг өөрөө шийдэх ямар ч бололцоогүй болдог. “Хэрвээ эмэгтэйчүүдийн ертөнц ба улс төр хоёр интеграцчилалд орсон байсансан бол орчин үед улс төрийн амьдралд эмэгтэй хүний оролцоо ба “эмэгтэй хүний асуудал” хэмээн шошго зүүсэн олон асуудал сонин хачин үзэгдэл болох ёсгүй байв. Үнэн хэрэгтээ гэр бүлийн хувийн амьдрал болон улс төрийн нийгмийн амьдрал хоёр бие биеэсээ салшгүй оршдог байсан бол мөн гэр бүлийн болон нийгмийн үүргүүдийг эрэгтэй эмэгтэй хүмүүс хоорондоо тэнцүү хувааж чадсан бол “эмэгтэй хүний асуудал” гэж юуг хэлэх байсан болоо”⁹.

Интеграцийн баримтлал бол эмэгтэйчүүд улс төрд оролцохыг зөвтгөж буй ноцтой үндэслэгээ юм. Гэвч угтаа эмэгтэйчүүдийн нийгэм дэх шоовдор байдал нь тэднийг улс төрд өргөн хүрээгээр оролцоход саад болж байна.

Энд нэг зүйлийг тэмдэглэх шаардлагатай байна. Үүнд, феминист онолчид шоовдор байдлыг зөвхөн эмэгтэйчүүдтэй холбоотой төдий биш, харин нийгмийн шударга бус байдал, тэгш бус байдал, дарлал мөлжлөгийн золиос болж байгаа

⁸ Pateman Carole. The sexual contract. Stanford University Press, 1988, p.114

⁹ Sapiro Virginia. The Political integration of woman. Illinois UP. 1984. p.7

аливаа хүний оршихуйн үндсэнд байдаг зүйл гэсэн өргөн утгаар авч үзэж байна. Хүн амын зарим бүлгүүд нь тэдгээрийн тооноос хамаарахгүйгээр өөрсдийн үзэл бодлыг илэрхийлэх бололцоогүйнхээ улмаас үл үзэгдэх байдалд орж, улс төрийн утгаараа хавчигдан гадуурхагдсан цөөнх болдог. Хүмүүс зөвхөн нийгмийн тэгш бус байдал, баялгийн тэгш бус хуваарилалтын улмаас төдийгүй, мөн танин мэдэхүйн өөрийнх нь бүтэц, зохион байгуулалтын улмаас нэг бүлгийнхэн объектив, "үнэн" мэдлэгийн төлөөлөгч мэт болж, харин бусад нь шоовдор байдалд ордог. Энэ утгаараа "үнэн" мэдлэгийг бүтээгч, зөөгч нь эрэгтэйчүүд болж, эмэгтэйчүүд түүнд тааруулан биеэ авч явах шаардлагатай болдог гэж феминистүүд эмзэглэн бичдэг билээ..

Резюме

В данной статье авторами были освещены проблемы дискриминации женщин и других маргинальных групп общества. В современном мире стал актуальным пересмотр политики в отношении широкого комплекса проблем, которые традиционно характеризовались в качестве женских и раньше относились к разряду вторичных. И политическая активизация "пассивных" и "незаметных" прежде групп, в том числе женщин, поставила вопросы об их реальном влиянии на процессы принятия решений

НОМ ЗҮЙ

1. Симона де Бовуар. Второй пол. / Пер. с французского, СПб., 1997
2. Миллет К. Теория сексуальной политики. / Пер. с англ. Вопросы философии. 1999. №9
3. Маркс К., Энгельс Ф. Түүвэр зохиол. 3-р боть. УБ.: 1997
4. Pateman Carole. The sexual contract. Stanford University Press, 1988
5. Sapiro Virginia. The political integration of women. University of Illinois Press 1972